

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2020 оны... дугаар
сарын -ний... өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2020 онд нэмэлтээр экспортлох
стратегийн зарим хүнсний тоо, хэмжээний тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 18 дугаар зүйлийн 18.5-д тус тус заасныг үндэслэн Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлөөс ЗӨВЛӨМЖ болгох нь:

1. 2020 онд нэмэлтээр экспортлох стратегийн хүнс болох дулааны аргаар боловсруулсан хонь, ямааны махны хэмжээг 40.000 /дөчин мянга/ тонн хүртэл байхаар тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд зөвлөсүгэй.
2. Монгол Улсын 2020-2021 оны хүйтэн улирлын төлөв байдлыг үндэслэн Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгаас бог мал бэлтгэх ажлыг экспортын эрх бүхий аж ахуйн нэгжтэй хамтран шуурхай зохион байгуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

У.ХҮРЭЛСҮХ